



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/713

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Хэнтий аймгийн Дадал суманд байрлах “Дэлүүн болдог” нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх, олон улсын зэрэглэлтэй болгох, судалгаа хийж дүгнэлт гаргах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ажлын хэсгийн үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг төсвийн дагуу гарган зарцуулахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Ч.Нямсүрэн/-т зөвшөөрсүгэй.

3. Ажлын хэсгийн тайлан, дүгнэлтийг Иргэний нисэхийн ерөнхий газрын Даргын зөвлөлд 2018 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсгийн дарга /С.Мөнхнасан/-д даалгасугай.

ДАРГА — Л.БЯМБАСҮРЭН

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн
А/913... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН ДАДАЛ СУМАНД БАЙРЛАХ "ДЭЛҮҮН БОЛДОГ"
НИСЭХ БУУДЛЫН ХҮЧИН ЧАДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, СУДАЛГАА
ХИЙХ, ДҮГНЭЛТ ГАРГАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	С.Мөнхнасан	Нисэх буудлуудын удирдах газрын дэд дарга
Нарийн бичгийн дарга:	О.Баасансүрэн	Нисэх буудлуудын удирдах газрын Төсөл, хөтөлбөр боловсруулалтын тасгийн төсөл хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Г.Мөнхболд	Нисэх буудлуудын удирдах газрын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Ц.Мөнхжаргал	Нисэх буудлуудын удирдах газрын Хамтын ажиллагаа, эдийн засгийн зохицуулалтын тасгийн дарга
	Г.Сүх-Очир	Нисэх буудлуудын удирдах газрын Төсөл, хөтөлбөр боловсруулалтын тасгийн дарга
	Б.Гэрэлбат	Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх албаны дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн
	Б.Эрдэнэбаатар	Нисэх буудлуудын удирдах газрын Үйлдвэр, үйлчилгээний хэлтсийн Аэродромын үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
	А.Нямдагва	Оношилгоо хэмжил зүйн лабораторийн шугаман өнцөг, геодезийн инженер

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн
А/73 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН ДАДАЛ СУМАНД БАЙРЛАХ "ДЭЛҮҮН БОЛДОГ"
НИСЭХ БУУДЛЫН ХҮЧИН ЧАДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, СУДАЛГАА
ХИЙХ, ДҮГНЭЛТ ГАРГАХ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

ЗОРИЛГО:

Хэнтий аймгийн Дадал суманд байрлах "Дэлүүн болдог" нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх, олон улсын зэрэглэлтэй болгох талаар судалгаа хийж дүгнэлт гаргахад оршино.

ХИЙГДЭХ АЖИЛ:

1. Дадал сумын Засаг дарга болон холбогдох албаны хүмүүстэй уулзаж Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 142 дугаар тогтоолоор батлагдсан "Хөгжлийн зам" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, сумын хөгжлийн хөтөлбөр болон газар зүйн нөхцөл, цаг уурын талаар шаардлагатай мэдээ, мэдээллийг авах;

2. "Дэлүүн болдог" нисэх буудлын аэродромын элементүүд болон хашаа, хамгаалалт байршилд үзлэг хийх, цаашид өргөтгөх боломжит зай талбайг судалж тогтоох;

3. "Дэлүүн болдог" нисэх буудлыг 4С ангиллын хяналтын код бүхий аэродром болгон өргөтгөх боломжтой шинэ байршлын судалгаа хийх;

4. Судалгаагаар боломжит байршил тогтоогдсон нөхцөлд тухайн газарт шинээр төлөвлөлт, хөөрч буух зурвасын чиглэл болон урт, газар зүйн байршлын хэмжилтийг хийх, хэрэглэлээр ойртолт үйлдэх боломжит нөхцөлүүдийг тооцоолно;

ТАЙЛАН:

Ажлын хэсгийн тайлан, дүгнэлтийг Иргэний нисэхийн ерөнхий газрын Даргын зөвлөлд 2018 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулна.

xxx xxx xxx